



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙД УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2017. 10. 27 № 13

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:


Нэг. Монгол Улсын Ерөнхий сайд Таны танхимд ажиллаж буй Хууль зүй, дотоод хэргийн сайдтай холбоотой асуудлаар Тагнуулын ерөнхий газраас албан ёсны хэвлэлийн хурал хийж Ц.Нямдорж сайдыг БНХАУ-ын тагнуул мөн эсэх талаар хяналт шалгалт явуулсан хавтаст хэргийг нууцын зэрэглэлээс гаргах бүрэн боломжтой болсон талаар мэдэгдсэн. Мэргэжлийн байгууллагын зүгээс албан ёсны мэдэгдэл олон нийтэд гарсан тул уг асуудлыг нууцын зэрэглэлээс гаргаж хууль тогтоох дээд байгууллага болон иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэл өгөх шаардлагатай байна.

Хоёр. Тухайн хэвлэлийн хурлын үеэр Ц.Нямдорж сайд нь “Эрдэнэт Үйлдвэр” ХХК-д хийсэн 42.0 сая ам.долларын шахааны бизнест холбогдсон талаар мөн дурджээ. Орхон аймгаас сонгогдсон гишүүний хувьд би “Эрдэнэт Үйлдвэр” ХХК-тай холбогдсон аливаа шахааны бизнесийг хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгтэй шууд болон шууд бусаар оролцсон аливаа этгээд нь танай танхимд хэрэв байгаа тохиолдолд ёс зүйгүй асуудал хэмээн үзэж байна.

Иймд дээрх хоёр асуулгын дагуу Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасан хугацаанд бичгээр ирүүлж 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Улсын ерөнхий прокурор, Авилгатай тэмцэх газраас холбогдох албан тушаалтнуудыг байлцуулан сонсохыг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



О.БААСАНХҮҮ